

“ШИНЭ АНАГААХ УХААН” ДЭЭД СУРГУУЛЬ

“ШИНЭ АНАГААХ УХААН” ДЭЭД СУРГУУЛИЙН 2015 ОНЫ ТӨГСӨГЧДИЙН МӨШГИХ ТУРШИЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Тайлан бичсэн:

Сургалтын албаны мэргэжилтэн Б.Ганзориг

Улаанбаатар 2017

Зургийн жагсаалт

Зураг 1 Нас.....	4
Зураг 2 Хүйсны байдал.....	4
Зураг 3 Дүнгийн дундаж	5
Зураг 4 Төгсөгчдийн ажиллаж буй байгууллагын төрөл	5
Зураг 5 Төгсөгчдийн дахин суралцаж буй чиглэл.....	6
Зураг 6 Төгсөгчдийн төгссөнөөс хойшхи ажилгүй байсан хугацаа	6
Зураг 7 Төгсөгчдийн ажил эрхлэлт	7
Зураг 8 Төгсөгчдийн ажил эрхэлсэн мэдээллийн эх сурвалж.....	7
Зураг 9 Төгсөгчдийн цагийн ачаалал.....	8
Зураг 10 Төгсөгчдийн дундаж цалин орлого.....	9
Зураг 11 Хөдөлмөр эрхлэлт давхардал	9
Зураг 12 Төгсөгчдийн ажилгүй байгаа шалтгаан	10
Зураг 13 Төгсөгчдийн ажлаас гарсан шалтгаан.....	10

Хүснэгтийн жагсаалт

хүснэгт 1 Сургалтын хөтөлбөрөөр эзэмшүүлсэн ур чадварын сэтгэл ханамж	11
хүснэгт 2 Сургалтын хөтөлбөрийн давуу болон сул тал	12

“Шинэ Анагаах Ухаан” дээд сургуулийн 2015 оны төгсөгчдийн судалгаа

Судалгааны зорилго:

Манай сургуулийн уламжлалт анагаах ухааны сургалтын хөтөлбөрийн бүрэн агуулгаар суралцан төгссөн төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл дээрх одоогийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, сурсан хөтөлбөрийн сэтгэл ханамжийг судлан тогтоож, төгсөгчдийн зүгээс гарсан санал хүсэлтийг харгалзан цаашид сургалтын хөтөлбөрийг улам бүр боловсронгуй болгоход бидний судалгааны зорилго оршиж байна.

Судалгааны зорилт:

- Төгсөгчдийн мэдээллийг цахим ашиглан цуглуулж тогтоох
- Төгсөгчдийн одоогийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харьцуулан судлах
- Төгсөгчдийн ажлын байрны мэдээллийг тогтоох
- Төгсөгчдийн сурсан хөтөлбөрийн сэтгэл ханамжийг үнэлэх

Судалгааны арга зүй:

Төгсөгчдийг мөшгих туршилт судалгаанд IRIMongolian судалгааны хүрээлэнгийн боловсруулсан арга зүйг ашиглан мэдээлэл цуглуулах арга хэрэгслүүдээр дамжуулан цуглуулж авсан мэдээлэлдээ тулгуурлан дүн шинжилгээ хийсэн. Судалгааны үндсэн мэдээллийг 2017 оны 05–06 сарын хугацаанд төгсөгчдийн холбооны мэдээлэл дээр тулгуурлан тухайн үед анги удирдсан дарга, багш нартай холбогдож, цахим шуудан илгээх замаар асуулга бөглөж авсан.

Судалгааны хамрах хүрээ, түүвэр:


Судалгааг 2017 оны 05 сарын 20-ноос 06 сарыг дуустал 113 төгсөгч рүү <https://docs.google.com/forms/d/1bFAZ6CkmFumupBwrLueK8rEzrmjkM0PRUrVI948J0JI/e/dit> цахим шуудангаар сүлжээгээр дамжуулан асуулгыг хүргэж бөглүүлэх замаар хандалт хийхэд 69 төгсөгч судалгаанд хамрагдсан байгаа нь нийт төгсөгчдийн 61.06% оролцсон байна. Түүврийн хэмжээг сонгохдоо нийт төгсөгчдийг төлөөлөх чадвартай ажил олгогчийн түүврийн хэмжээг сонгохдоо итгэх магадлал 95 хувь, алдааныхязгаар +/-3 хувиасхэтрүүлэхгүйгээртусгай томъёогоор тооцоолсон болно.

Судалгааны үр дүн

Манай сургуулийг 2015 онд 113 уламжлалт анагаах ухааны их эмч мэргэжилтэн төгссөн байна. Төгсөгчдийн мэдээллийн хэсэг нь төгсөгчдийн овог нэр, нас, хүйс, төгссөн сургуулийн нэр, эзэмшсэн мэргэжил, хөтөлбөр, төгссөн он, сар, төгсөгчдийн амьдарч буй газар зүйн байршил зэрэг мэдээллийг агуулагдаж байгаа болно. Судалгаанд 113 төгсөгч оролцох байснаас 69 төгсөгчтэй цахим асуулгаар судалгааг авсан болно.

Нас

69 responses




Зураг 1 Нас

2015 оны төгсөгчдийн насны байдлаар судлан үзэхэд 85.9 хувийг 25-29 насны залуучууд эзэлж байсан бол харин 30-40 насны төгсөгчид 12,9 %-ийг эзэлж байв.

Хүйс

69 responses




Зураг 2 Хүйсны байдал

Судалгаанд хамрагсдыг хүйсийн байдлаар авч үзэхэд 9 (13%) эрэгтэй байсан бол 60 (87%) эмэгтэй байна.

Дипломын голч дүн



64 responses




Зураг 3 Дүнгийн дундаж

Судалгаанд оролцогсдын дипломын голч дүнгээр авч үзэхэд дипломын голч дүнг сургалтын байгууллагуудын суралцагсдад тавигдах шаардлагатай харьцуулахад 2.8-3.92 байгаа нь төгсөгчдийн мэдлэг, ур чадварын түвшин сайн байна.

Байгууллагын төрөл

47 responses




Зураг 4 Төгсөгчдийн ажиллаж буй байгууллагын төрөл

Судалгаанд оролцсон 69 төгсөгчдийн 68.1 хувь нь аж ахуй нэгж байгууллагад хөдөлмөр эрхлэх болон суралцаж байна. Ажиллаж буй аж ахуй нэгж байгууллага байгууллагуудыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй шатлал, хэлбэрээр авч үзэхэд 57.4 хувь нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллага болох сум, тосгоны эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа бол 17 хувь нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт, 12.8 хувь нь

төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан байна. Үүнээс дүгнэхэд шинэ төгсөгч нар сум, тосгоны эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байна.

Хэрвээ суралцаж байгаа бол

15 responses




Зураг 5 Төгсөгчдийн дахин суралцаж буй чиглэл

Судалгаанд оролцсон 69 төгсөгчдийн 12.8 хувь нь дахин суралцаж байна. Дахин суралцаж буй төгсөгчдийн суралцаж буй чиглэл хэлбэрийг тодруулахад 46.7 хувь нь эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад, 20 хувь нь гадаадад магистрантурт, 13.3 хувь нь дотоодын их, дээд сургуулиудын магистрантурт болон өөр мэргэжлээр тус тус суралцаж байна. Шинэ төгсөгчдийн ихэнх нь үндсэн мэргэжил олгох сургалтад суралцаж байгаа нь эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй холбоотой байж болох талтай байна.

Сургууль төгссөнөөс хойш хэдэн сар ажилгүй байсан бэ?

54 responses




Зураг 6 Төгсөгчдийн төгссөнөөс хойшхи ажилгүй байсан хугацаа

Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн сургууль төгссөний дараа хэдий хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлсэн байдлыг судлахад 1 сарын хугацаанд ажилтай

бол төгсөгч 18.5 хувь, 3-6 сарын хугацаанд 46.3 хувь, 6-12 сар 13 хувь байсан бол 1 жилээс дээш ажилгүй байсан төгсөгч нийт төгсөгчдийн 22.2 хувийг эзэлж байна. Энэ нь эрүүл мэндийн салбарийн хөдөлмөрийн зах зээл дэхь эрэлт хэрэгцээнээс хамаарахаас илүүтэй шинэ залуу хүмүүсийн хувьд гэр бүл төлөвлөх, хүүхдээ асрах, дахин суралцах зэрэг хүчин зүйлтэй холбоотой байж болох талтай байна.

Ажил эрхлэлтийн одоогийн байдал

63 responses



Зураг 7 Төгсөгчдийн ажил эрхлэлт

Төгсөгчдийн одоо эрхэлж буй ажлын байдлыг судлан үзэхэд 68.3 хувь нь эрүүл мэндийн салбарын эмнэлгийн аж ахуй, нэгж байгууллагад ажлын байран дээр үндсэн орон тооны ажил эрхэлж байна. Энэ нь урт удаан тогтвор суурьшилтай ажиллах ажилтанг авах сонирхол аж ахуй нэгж, байгууллагад их байдаг байна. Энэ нь нийт төгсөгчидтэй харьцуулахад 31.7 хувь нь ажилгүй, гэрийн ажил хийж байгаа, хүүхдээ асрах, суралцсан, мэргэжлийн бус ажил, ажиллах боломжгүй байгаа гэсэн олон талт хүчин зүйлээс хамааралтай байна.

Одоогийн ажлын байрныхаа мэдээллийг хаанаас олж авсан бэ?

52 responses




Зураг 8 Төгсөгчдийн ажил эрхэлсэн мэдээллийн эх сурвалж

Төгсөгчдийн анх ажилд ороход ашигласан мэдээллийн эх сурвалжийг судлан үзэхэд 32.7 хувь нь найз, нөхөд хамаатнаар дамжуулж орсон бол 26.9 хувь нь өөрөө тус байгууллагад ажиллах өргөдөл гаргасан, интернетээс 19.2 хувь нь, сургууль багшаар дамжуулж 7.7 хувь нь тухайн аж ахуй, нэгж, байгууллагад ажилд тус тус ажилд орсон байна. Үүнээс дүгнэн үзвэл найз, нөхөд хамаатнаар дамжуулан тухайн байгууллагад ажилд ордог болох нь харагдаж байна.

Долоо хоногт дунджаар хэдэн цаг ажилладаг вэ?

47 responses




Зураг 9 Төгсөгчдийн цагийн ачаалал

Төгсөгчдийн ажлын байрны хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн долоо хоногт ажиллах дундаж цагийн ачааллыг судлан үзэхэд 53,2 хувь нь 40-50 цаг ажиллаж байна. Энэ нь эмчийн ажлын ачаалал ихэсгэж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар ахиц буурч байгаатай холбоотой байна.

Эрхэлж буй ажлын сарын үндсэн цалин хэдэн төгрөг вэ?



47 responses




Зураг 10 Төгсөгчдийн дундаж цалин орлого

Судалгаанд нийт төгсөгчдийн 68.1 хувь нь хамрагдсан бөгөөд эрхэлж буй ажлын үндсэн цалинг судлан үзэхэд 500000-600000 төгрөгийн орлоготой - 38.3 хувь, 400000-500000 төгрөгийн орлоготой 23.4 хувь, 600000-700000, 700000-800000, 800000-1000000 хүртэх орлоготой тус тус 12.8 хувь байгаа нь төгсөгчдийн дийлэнх нь Монгол улсын 2017 оны хөдөлмөрийн зах зээлийн дундаж орлогоос бага орлоготой байгааг харуулж байна. Ийнхүү цалингийн түвшин бага байгаа нь төгсөгчдийн ажлын байрны албан тушаал, мэргэжил дээшлүүлсэн байдал болон эрдмийн зэрэг цол зэрэг ажлын туршлага, ажилласан жил бага байгаатай холбоотой гэж үзэж болох юм.

Өөр ажил давхар эрхэлдэг эсэх?

56 responses




Зураг 11 Хөдөлмөр эрхлэлт давхардал

Төгсөгчдийн давхар хөдөлмөр эрхэлдэг эсэхийг судлан үзэхэд 83.9 хувь нь давхар ажил хийхгүй байгаа нь аж ахуй нэгж, байгууллагын ажлын ачаалалаас шууд хамааралтай буюу долоо хоногт 40-50 цаг ажиллаж байгаатай холбоотой байна.

Ажилгүй бол ямар шалтгааны улмаас

19 responses




Зураг 12 Төгсөгчдийн ажилгүй байгаа шалтгаан

Судалгаанд оролцогч нийт төгсөгчдийн 68.1 нь хувь ажил, хөдөлмөр эрхэлж байгаа бол 31.7 нь хувь тодорхой эрхэлсэн ажилгүй байна. Ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгааныг судлан үзэхэд 57.9 хувь нь ажил хайхгүй байгаа буюу шалтгааныг тодруулахад хүүхэд төрүүлсэн, асрах шалтгаантай байсан бол 15.8 хувь нь үргэлжлүүлж сурч байгаа, 10.5 хувь нь эрүүл мэндийн болон бусад шалтгаан тус тус эзэлж байна. Энэ нь шинэ залуу төгсөгчдийн олонх нь гэр бүл болж, үр хүүхэд төрүүлэх, тэднийг асрах насан дээр байдагтай холбоотой гэж үзэж болох юм.

Ажиллаж байгаад ажлаас гарсан шалтгаан юу вэ?

12 responses



Зураг 13 Төгсөгчдийн ажлаас гарсан шалтгаан

Төгсөгчдийн ажиллаж байгаад өөрөө ажлаасаа гарсан шалтгааныг тодруулахад 41.7 хувь нь бусад гэж хариулсан байгаа нь шинэ төгсөгчдийн ажлын ур чадвар, туршлага харьцангуй бага байгаатай холбоотойгоор тэдний ажлын үнэлэмж, авч буй цалингийн хэмжээ амьжиргааны түвшинд нь хүрэлцэхгүй байгаа нийгмийн асуудалтай холбоотой гэсэн дүгнэлтийг хийх байна/В1-В3/.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Манай сургууль нь УАУ 722000 хөтөлбөрөөр уламжлалт анагаах ухааны хүний их эмч мэргэжилтэн бэлтгэж байгаа бөгөөд 2015 онд төгссөн төгсөгчдийн дунд сургалтын хөтөлбөр танд дараах чадваруудыг хэр сайн олгосон буюу сэтгэл ханамжийн (1-сэтгэл огт ханамжгүй, 2-сэтгэл ханамжгүй, 3-дунд зэрэг, 4-сэтгэл ханамжтай, 5-сэтгэл маш их ханамжтай) байдлыг 13 үзүүлэлтээр, хөтөлбөрийн давуу, сул талыг 11 үзүүлэлтийн дагуу төгсөгч нараар бөглүүлж, мэдээллийгсудалгааны программд тулгуурлан өөр хооронд нь харьцуулах аргаар үр дүнг дүгнэхэд сургалтын хөтөлбөрт өгсөн сэтгэл ханамжийн хувьд дийлэнх төгсөгч сэтгэл ханамжтай, давуу талтай гэж үнэлсэн байна.

Манай сургуульд сурсан хөтөлбөр танд дараах чадваруудыг хэр сайн олгосон гэж үзэж байна вэ? /Мөр бүрт сонгож тэмдэглэнэ үү/

хүснэгт 1 Сургалтын хөтөлбөрөөр эзэмшүүлсэн ур чадварын сэтгэл ханамж

	Маш их	Их	Дунд зэрэг	Бага	Маш бага их
Манлайлах чадвар	8	28	26	4	0
Бие даан ажиллах чадвар	12	35	17	2	0
Багаар ажиллах чадвар	21	22	18	2	1
Зохион байгуулах чадвар	14	30	18	2	1
Цагийн менежмент	19	29	15	1	2
Санаачлах, эрсдэл хүлээх чадвар	15	30	16	3	2
Санаачлах, эрсдэл хүлээх чадвар	25	28	9	1	2
Компьютер, интернет ашиглах чадвар	7	21	31	4	2
Тухайн ажил мэргэжлийн мэдлэг	13	31	18	1	3
Тухайн жил мэргэжлийн эзэмших ур чадвар олголт	11	31	14	5	1
Гадаад хэлний мэдлэг	5	9	34	12	5
Ачаалал ихтэй ажиллах чадвар	17	29	14	4	1
Бизнес эрхлэх ур чадвар	5	16	27	10	7

Манай сургуулийн УАУ-D722000 сургалтын хөтөлбөрөөр эзэмшүүлвэл зохих ур чадварууд, түүний эзэмшүүлэлтийн сэтгэл ханамжийг судлан үзэхэд Санаачлах, эрсдэл хүлээх болон багаар ажиллах ур чадвар эзэмшилт дээр сэтгэл ханамж маш их гэж онцолсон байна. Мөн Бие даан ажиллах, тухайн ажил мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх тал дээр сэтгэл ханамжтай гэж үзсэн байна. Харин компьютер, бизнес эрхлэх ур чадвар болон гадаад хэлний мэдлэгийн чадварууд дээр сэтгэл дундуур байгаагаа илэрхийлсэн байна. Энд олон шалтгаан, хүчин зүйл байх боломжтой хэдий ч голдуу ажлын байрны тавигдах шаардлагад нийцвэл зохих чадваруудыг эзэмшсэн байдал нь хувь хүний идэвхи чармайлт, хувийн зан чанар болон сургалтын хөтөлбөртэй зарим талаараа холбоотой байх хэдий ч төгсөгчдийн

ажлын туршлага бага, мэргэжлээрээ цөөн жил ажилласантай түлхүү холбоотой байх магадлал өндөр байна. Мөн түүнчлэн бизнес эрхлэх сэтгэл ханамжгүй гэж үнэлсэн байгаа нь мэргэжлийн онцлогтой холбоотой байна. Тиймээс цаашид төгсөн гарч буй мэргэжилтний ачаалал даах чадварыг дээшлүүлэх, бизнес эрхлэх чадваруудыг хөгжүүлэх тал дээр анхаарах нь зүйтэй байна. Дээр бүгдийг дүгнэвэл нийт төгсөгчдийн ур чадваруудад өгсөн үнэлгээний ерөнхий түвшингээр 2014 оны төгсөгчдийн 60-аас дээш хувь нь сэтгэл ханамжтай байна. Цаашид манай сургууль сургалтын хөтөлбөрөөр эзэмшүүлвэл зохих хэд хэдэн ур чадвар дээр онцгойлон анхаарч, хувь хүний хөгжил болон сургах арга барилын талаас аль алиныг хослуулан хөгжүүлэх хэрэгцээтэй байгаа нь харагдлаа.

Дараах зүйлсийн аль нь манай сургуулийн хөтөлбөрийн давуу ба сул тал болдог гэж та үзэж байна вэ?

хүснэгт 2 Сургалтын хөтөлбөрийн давуу болон сул тал

	Давуу тал	Боломжийн	Дундаж	Сул тал	Мэдэхгүй
Судлах хичээлийн тоо	19	23	11	9	0
Заавал үзэх хичээл ба сонгох хичээлийн харьцаа	10	23	15	9	0
Оюутны ачаалал	8	20	20	9	0
Багш нарын чанар	17	27	9	6	1
Анги танхим, тоног төхөөрөмж	21	23	15	3	0
Бусад мэргэжил/хөтөлбөрөөс суралцах боломж	5	20	19	10	1
Судалгааны чадавхи	18	20	10	10	2
Хөдөлмөрийн зах зээлд зохицох байдал	6	21	14	14	3
Үйлдвэрлэлийн салбартай хамтрах байдал	6	22	18	9	3
Сургалтын төлбөр	6	25	17	8	4
Бусад	2	6	5	3	1

Манай сургуулийн хөтөлбөрийн давуу, сул талыг дараах үзүүлэлтүүдээр судлан үзэхэд анги, тоног төхөөрөмж, судалгааны чадавхи, багшийн чанар, хичээлийг тоог тус тус давуу гэж үнэлсэн бол сургалтын төлбөр, багшийн чанарыг боломжийн, оюутны ачаалал, Үйлдвэрлэлийн салбартай хамтрах байдал, Сургалтын төлбөрийг дундаж, хөдөлмөрийн зах зээлд зохицох байдалд сул талтай гэж үнэлсэн байна. ерөнхийдээ дээрх үзүүлэлт тус бүрд төгсөгчдийн 50-иас дээш хувь нь илүү сайн гэж дүгнэсэн байна. Эндээс дүгнэж үзвэл манай сургуулийн сургалтын технологи, орчин, материаллаг бааз, багшлах боловсон хүчний ур чадвар зэрэг нь хөдөлмөрийн зах зээлд нийцэж байгаа нь харагдаж байгаа ч цаашид хөтөлбөрийг илүү сайжруулах зарим нэгэн шаардлага, санал байна. Ялангуяа хөдөлмөрийн зах зээлд зохицох байдалд сул гэж үнэлсэн байгаа нь цаашид сургуулийн хөтөлбөрт энэ тал дээр анхаарах хэрэгтэй бөгөөд үйлдвэрлэлийн салбартай хамтрах буюу эмнэлгийн орчинд дадлагажих нөхцөл боломж дээр дүн шинжилгээ хийх хэрэгтэй байна.

Дүгнэлт:

1. Төгсөгчдийн 85.7 хувь нь 25-29 насны 87 хувь эмэгтэй хамрагдсан бөгөөд дипломын дүн голч 2.8-3.92-той байна.
2. Судалгаанд оролцсон 69 төгсөгчдийн 68.1 хувь нь аж ахуй нэгж байгууллагад хөдөлмөр эрхлэх болон суралцаж байгаагаас 74.4 хувь нь эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажилллаж байна.
3. Төгсөгчдийн 12.8 хувь нь дахин суралцаж буй төгсөгчдийн суралцаж буй чиглэлийг тодруулахад 46.7 хувь нь эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдаж байгаа нь ажлын байрны эрэлт хэрэгцээтэй шууд хамааралтай байна.
4. Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн сургууль төгссөний дараа хэдий хугацаа харилцан адилгүй байсан бөгөөд энэ нь эрүүл мэндийн салбарийн хөдөлмөрийн зах зээл дэхь эрэлт хэрэгцээнээс хамаарахаас илүүтэй шинэ залуу хүмүүсийн хувьд гэр бүл төлөвлөх, хүүхдээ асрах, дахин суралцах зэрэг хүчин зүйлтэй холбоотой байж болох талтай тул цаашид дэлгэрүүлэн судлах зүйтэй байна.
5. Төгсөгчдийн одоо эрхэлж буй ажлын байдлыг судлан үзэхэд 68.3 хувь нь эрүүл мэндийн салбарын эмнэлгийн аж ахуй, нэгж байгууллагад ажлын байран дээр үндсэн орон тооны ажил эрхэлж байна. Энэ нь урт удаан тогтвор суурьшилтай ажиллах ажилтанг авах сонирхол аж ахуй нэгж, байгууллагад их байдаг байна.
6. Төгсөгчдийн анх ажилд ороход ашигласан мэдээллийн эх сурвалжийг судлан үзэхэд 32.7 хувь нь найз, нөхөд хамаатнаар дамжуулан тухайн байгууллагад ажилд ордог болох нь харагдаж байна.
7. Төгсөгчдийн ажлын байрны хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн долоо хоногт ажиллах дундаж цагийн ачааллыг судлан үзэхэд 53,2 хувь нь 40-50 цаг ажиллаж байгаа нь эмчийн ажлын ачаалал ихэсгэж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар нөлөөлж байна. Нөгөөтэйгүүр эмч нарт давхар ажиллах боломжгүй, өөрийгөө хөгжүүлэхэд цаг бага зарцуулдаг байж болохоор байна.
8. Судалгаанд нийт төгсөгчдийн төгсөгчдийн дийлэнх нь Монгол улсын 2017 оны хөдөлмөрийн зах зээлийн дундаж орлогоос бага орлоготой байгааг харуулж байна.
9. Судалгаанд оролцогч нийт төгсөгчдийн 31.7 нь хувь тодорхой эрхэлсэн ажилгүй байгаа нь шинэ залуу төгсөгчдийн олонх нь гэр бүл болж, үр хүүхэд төрүүлэх, тэднийг асрах насан дээр байдагтай холбоотой гэж үзэж болох юм.
10. Төгсөгчдийн ажиллаж байгаад өөрөө ажлаасаа гарсан шалтгааныг тодруулахад 41.7 хувь нь бусад гэж хариулсан байгаа нь шинэ төгсөгчдийн ажлын ур чадвар, туршлага харьцангуй бага байгаатай холбоотойгоор тэдний ажлын үнэлэмж, авч буй цалингийн хэмжээ амьжиргааны түвшинд нь хүрэлцэхгүй байгаа нийгмийн асуудалтай холбоотой гэсэн дүгнэлтийг хийх байна.
11. Манай сургуулийн сургалтын хөтөлбөрөөр эзэмшүүлвэл зохих ур чадварууд, түүний эзэмшүүлэлтийн сэтгэл ханамжийг судлан үзэхэд ихэнхи буюу багаар

ажиллах, бие даан ажиллах, тухайн ажил мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх ур чадвар эзэмшилт дээр ханамжтай сэтгэл ханамж дундаас дээш байсан бол цөөн тооны компьютер, бизнес эрхлэх ур чадвар болон гадаад хэлний мэдлэгийг чадварууд сэтгэл дундуур байгаагаар илэрхийлсэн байна. Тиймээс цаашид төгсөн гарч буй мэргэжилтний ачаалал даах чадварыг дээшлүүлэх, бизнес эрхлэх чадваруудыг хөгжүүлэх тал дээр анхаарах нь зүйтэй байна.

12. Манай сургуулийн хөтөлбөрийн давуу, сул талыг дараах үзүүлэлтүүдээр судлан үзэхэд анги, тоног төхөөрөмж, судалгааны чадавхи, багшийн чанар, хичээлийг тоо, сургалтын төлбөр, оюутны ачаалал, үйлдвэрлэлийн салбартай хамтрах байдалыг давуу тал гэж үнэлсэн бол хөдөлмөрийн зах зээлд зохицох байдалд сул талтай гэж үнэлсэн байна. Цаашид сургуулийн хөтөлбөрт энэ тал дээр анхаарах хэрэгтэй бөгөөд үйлдвэрлэлийн салбартай хамтрах буюу эмнэлгийн орчинд дадлагажих нөхцөл боломж дээр дүн шинжилгээ хийх хэрэгтэй байна.